



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/10

Хатан суудал

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд
авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, сумын Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийг хурлын шийдвэр зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд архи, согтууруулах ундааг 7 хоног бүрийн Даваа, Баасан гарагуудад худалдан борлуулахыг хориглосугай.

2. Дэлгүүр, үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийг 10 цагаас 20 цаг байхаар тогтоосугай.

3. Дээрх заалтуудыг бүрэн хэрэгжүүлж зөрчил дутагдал гаргахгүй ажиллахыг нийт дэлгүүр, үйлчилгээний газрын эздүүдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтийг ханган, захирамжийг зөрчсөн дэлгүүр, үйлчилгээний газарт холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцож ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Г.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642101327